



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/50

Мандалговь

**Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Баянжаргалан сумын 3 дугаар багт баригдсан Шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Буманбаатар	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Баатарсүрэн	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд	Б.Золжаргал	(Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Ч.Нацагдорж	(Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч)
	А.Энхцэцэг	(Зураг төсөл зохиогч “Бета энерги” ХХК-ийн архитектор)
	Ц.Батзул	(Гүйцэтгэгч “Нарт импекс” ХХК-ийн инженер)
	Б.Энхжаргал	(“БЗӨБЦТС” ТӨХК-ийн Говьсүмбэр ЦТСС-ын Ерөнхий инженер)
	Р.Отгонбаатар	(Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын дарга)
	Т.Уранбайгаль	(Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)

D/ Alban bichig/ Tushaal 2024.10.03

4824010192

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Б.Буманбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЧАГНААДОРЖ